



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /22/ НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэ худалдан авах тухай хууль
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АО	Ажил олгогч
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.22 № 05
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Х.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,485,154.72</u>	<u>32,624,574.00</u>
33	АВЛАГА	<u>16,868,895.72</u>	<u>9,033,265.00</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	262,130.72	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	84,000.00	84,000.00
335	Бусад авлага	16,522,765.00	8,949,265.00
3351	Байгууллагаас авах авлага	366,265.00	366,265.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	16,156,500.00	8,583,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>27,616,259.00</u>	<u>23,591,309.00</u>
351	Түүхий эд материал	1,362,000.00	1,357,000.00
35130	Эм боох материал	1,362,000.00	1,357,000.00
354	Хангамжийн материал	26,254,259.00	22,234,309.00
35410	Бичиг хэргийн материал	437,000.00	0.00
35420	Аж ахуйн материал	23,326,959.00	21,769,309.00
35460	Хүнсний материал	842,800.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	1,647,500.00	465,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,500,694,186.61</u>	<u>1,571,354,022.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,500,694,186.61</u>	<u>1,571,354,022.21</u>
392	Биет хөрөнгө	1,370,868,277.36	1,452,114,022.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,295,241,603.00	1,295,241,603.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,042,648.54	-96,420,499.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	123,398,000.00	74,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-123,398,000.00	-74,998,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,627,026.26	362,018,080.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-201,617,750.56	-215,480,457.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	172,805,950.46	228,759,280.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,145,903.26	-122,003,984.74
393	Биет бус хөрөнгө	129,825,909.25	119,240,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	131,042,273.00	131,042,273.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,216,363.75	-11,802,273.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,545,179,341.33</u>	<u>1,603,978,596.21</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,545,179,341.33</u>	<u>1,603,978,596.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,545,179,341.33	1,603,978,596.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	604,452,423.60	604,452,423.60
51101	Өмч: - төрийн	604,452,423.60	604,452,423.60
512	Хуримтлагдсан үр дүн	768,513,977.20	827,313,232.08
51210	Өмнөх үеийн үр дүн	768,513,977.20	768,513,977.20
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	58,799,254.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172,212,940.53	172,212,940.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,545,179,341.33</u>	<u>1,603,978,596.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>1,172,855,202.00</u>	<u>1,031,973,630.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>242,869,227.00</u>	<u>206,055,530.00</u>



120	Нийтлэг татварын бус орлого	242,869,227.00	206,055,530.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	242,869,227.00	206,055,530.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,197,990.00	37,398,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	79,212,984.00	168,657,530.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929,985,975.00	825,918,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	710,491,600.00	694,533,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	710,491,600.00	694,533,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,494,375.00	131,385,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	10,635,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,099,375.00	103,385,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,395,000.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,365,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,057,214,987.04	973,174,375.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,057,214,987.04	973,174,375.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	988,091,802.04	946,109,979.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	688,969,547.00	627,316,538.31
210101	Үндсэн цалин	538,674,295.00	503,978,595.31
210102	Нэмэгдэл	137,307,957.00	108,425,575.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,987,295.00	14,912,367.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,111,735.00	80,200,593.60
210201	Тэтгэврийн даатгал	63,686,735.00	57,775,494.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,606,300.00	5,606,299.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,000.00	4,484,999.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,200.00	1,121,299.87
210205	Эрүүл мэндийн даатгал	11,212,500.00	11,212,499.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,970,454.00	30,116,821.00
210301	Гэрэл, цахилгаан	4,561,227.00	4,508,294.00
210302	Түлш, халаалт	11,739,407.00	11,283,445.00
210303	Цэвэр, бохир ус	12,669,820.00	14,325,082.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,264,410.00	28,756,790.00
210401	Бичиг хэрэг	3,913,010.00	7,562,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,900,000.00	4,382,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,562,200.00	4,083,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	580,000.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,309,200.00	7,131,400.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,216,450.00
2105	Нормативт зардал	22,639,114.00	20,059,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	925,900.00	1,205,000.00
210502	Хоол, хүнс	20,835,714.00	16,235,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	877,500.00	2,619,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,475,771.00	2,960,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	94,211.00	521,410.00
210604	Урсгал засвар	4,381,560.00	2,438,800.00
2107	Томилолт, зочны зардал	26,500.00	138,000.00



210702	Дотоод албан томилолт	26,500.00	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,974,570.00	26,177,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,285,500.00	24,177,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	239,570.00	154,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	93,290.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,500.00	772,500.00
210807	Газрын төлбөр	1,560,000.00	924,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,659,701.04	130,383,266.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,899,800.00	28,739,482.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,395,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,364,901.04	101,643,784.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,123,185.00	27,064,395.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,887,943.00	878,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,362,943.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,525,000.00	878,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,833,742.00	10,392,174.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,833,742.00	10,392,174.81
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,382,500.00	15,794,221.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,382,500.00	15,794,221.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,019,000.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,019,000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	115,640,214.96	58,799,254.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	38,853.63	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-38,853.63	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	115,601,361.33	58,799,254.88

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	768,513,977.20	1,545,179,341.33
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	768,513,977.20	1,545,179,341.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	768,513,977.20	1,545,179,341.33
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	58,799,254.88	58,799,254.88
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	827,313,232.08	1,603,978,596.21



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,007,688,965.00	870,889,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,197,990.00	37,398,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	51,197,990.00	37,398,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,197,990.00	37,398,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,197,990.00	37,398,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	956,490,975.00	833,491,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	710,491,600.00	694,533,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	710,491,600.00	694,533,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,999,375.00	138,958,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	10,635,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,099,375.00	103,385,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,395,000.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,505,000.00	8,938,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,004,648,975.00	866,839,710.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,004,648,975.00	866,839,710.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	935,525,790.00	839,775,314.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	688,969,547.00	627,054,407.59
210101	Үндсэн цалин	538,674,295.00	503,716,464.59
210102	Нэмэгдэл	137,307,957.00	108,425,575.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,987,295.00	14,912,367.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,111,735.00	80,200,593.60
210201	Тэтгэврийн даатгал	63,686,735.00	57,775,494.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,606,300.00	5,606,299.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,000.00	4,484,999.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,200.00	1,121,299.87
210205	Эрүүл мэндийн даатгал	11,212,500.00	11,212,499.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,970,454.00	30,116,821.00
210301	Гэрэл, цахилгаан	4,561,227.00	4,508,294.00
210302	Түлш, халаалт	11,739,407.00	11,283,445.00
210303	Цэвэр, бохир ус	12,669,820.00	14,325,082.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,668,200.00	23,299,840.00
210401	Бичиг хэрэг	4,041,100.00	7,125,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,900,000.00	4,382,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,562,200.00	4,083,640.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	580,000.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,584,900.00	7,327,900.00



2105	Нормативт зардал	28,078,514.00	20,493,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.00	1,200,000.00
210502	Хоол, хүнс	21,678,514.00	15,393,170.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,800,000.00	3,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,431,470.00	3,555,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,049,910.00	1,116,410.00
210604	Урсгал засвар	4,381,560.00	2,438,800.00
2107	Томилолт, зочны зардал	26,500.00	138,000.00
210702	Дотоод албан томилолт	26,500.00	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,974,570.00	26,177,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,285,500.00	24,177,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	239,570.00	154,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	93,290.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,500.00	772,500.00
210807	Газрын төлбөр	1,560,000.00	924,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,294,800.00	28,739,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,899,800.00	28,739,482.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,123,185.00	27,064,395.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,887,943.00	878,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,362,943.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,525,000.00	878,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,833,742.00	10,392,174.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,833,742.00	10,392,174.81
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,382,500.00	15,794,221.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,382,500.00	15,794,221.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,019,000.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,019,000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,039,990.00</u>	<u>4,049,890.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,039,990.00	4,049,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,039,990.00	4,049,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,039,990.00	4,049,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,039,990.00	4,049,890.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,039,990.00</u>	<u>-4,049,890.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	839,518,000.00	722,342,943.19	117,175,056.81	86.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	839,518,000.00	722,342,943.19	117,175,056.81	86.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	838,640,000.00	721,464,943.19	117,175,056.81	86.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,626,600.00	558,577,227.59	2,049,372.41	99.6%
210101	Үндсэн цалин	429,065,100.00	435,239,284.59	-6,174,184.59	101.4%
210102	Нэмэгдэл	113,411,500.00	108,425,575.28	4,985,924.72	95.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,150,000.00	14,912,367.72	3,237,632.28	82.16%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,684,600.00	71,704,594.60	3,980,005.40	94.7%
210201	Тэтгэврийн даатгал	53,259,500.00	49,279,495.76	3,980,004.24	92.5%
210202	Тэтгэмжийн даатгал	5,606,300.00	5,606,299.21	0.79	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,485,000.00	4,484,999.88	0.12	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,300.00	1,121,299.87	0.13	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,212,500.00	11,212,499.88	0.12	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,476,400.00	30,116,821.00	1,359,579.00	95.7%
210301	Гэрэл, цахилгаан	9,418,000.00	4,508,294.00	4,909,706.00	47.9%
210302	Түлш, халаалт	12,548,400.00	11,283,445.00	1,264,955.00	89.9%
210303	Цэвэр, бохир ус	9,510,000.00	14,325,082.00	-4,815,082.00	150.6%
2104	Хангамж, бараа материалын зардал	16,789,400.00	16,789,240.00	160.00	100.0%
210401	Бичиг хэрэг	3,316,100.00	3,316,100.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	2,699,600.00	2,699,600.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,065,800.00	3,065,640.00	160.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	380,000.00	380,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,327,900.00	7,327,900.00	0.00	100.0%
2105	Нормативт зардал	30,100,000.00	20,493,170.00	9,606,830.00	68.1%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	25,000,000.00	15,393,170.00	9,606,830.00	61.6%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,900,000.00	3,900,000.00	0.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,605,100.00	7,605,100.00	0.00	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,166,300.00	5,166,300.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	2,438,800.00	2,438,800.00	0.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	21,200.00	0.00	21,200.00	0.0%
210702	Дотоод албан томилолт	21,200.00	0.00	21,200.00	0.0%



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,336,700.00	16,178,790.00	100,157,910.00	13.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,885,000.00	14,178,900.00	98,706,100.00	12.6%
210803	Даатгалын үйлчилгээ	643,500.00	154,800.00	488,700.00	24.1%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	93,290.00	186,710.00	33.3%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,700.00	55,000.00	700.00	98.7%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	772,500.00	772,500.00	0.00	100.00%
210807	Газрын төлбөр	1,700,000.00	924,300.00	775,700.00	54.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	878,000.00	878,000.00	0.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	878,000.00	878,000.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	878,000.00	878,000.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	839,518,000.00	722,342,943.19	117,175,056.81	86.0%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,533,000.00	684,944,943.19	9,588,056.81	98.6%
131001	Улсын төсвөөс санхүүжих	694,533,000.00	684,944,943.19	9,588,056.81	98.62%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	144,985,000.00	37,398,000.00	107,587,000.00	25.79%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	144,985,000.00	37,398,000.00	107,587,000.00	25.79%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	50.00	50.00	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	50.00	50.00	0.00	100.00%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	36.00	36.00	0.00	100.00%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00	0.00	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	245,999,375.00	138,958,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,999,375.00	138,958,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,184,789.00	122,360,261.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,960,543.00	68,477,180.00
210101	Үндсэн цалин	133,960,543.00	68,477,180.00



2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,948,446.00	84,989,999.00
210201	Тэтгэврийн даатгал	15,948,446.00	84,989,999.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,981,000.00	6,510,600.00
210401	Бичиг хэрэг	1,546,000.00	3,809,600.00
210402	Тээвэр, шатахуун	180,000.00	1,683,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	255,000.00	1,018,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	138,000.00
210702	Дотоод албан томилолт		138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	9,999,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		9,999,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,294,800.00	28,739,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,899,800.00	28,739,482.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,395,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,814,586.00	16,598,339.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,814,586.00	16,598,339.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	413,086.00	804,118.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	26,382,500.00	15,794,221.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	7,019,000.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	245,999,375.00	138,958,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,999,375.00	138,958,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,505,000.00	10,635,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,099,375.00	103,385,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,395,000.00	16,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,938,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/114 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж иргэдэд үзүүлэх эрхэм зорилготой бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 839,460.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,394.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,876.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,799.3 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь үндсэн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	16,868.9	9,033.3	(7,835.6)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	27,616.2	23,591.3	(4,024.9)
Үндсэн хөрөнгө	1,500,694.2	1,571,354.0	70,659.8
Нийт хөрөнгө	1,545,179.3	1,603,978.6	58,799.3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,545,179.3	1,603,978.6	58,799.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,545,179.3	1,603,978.6	58,799.3

Мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 7,835.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгийн төсвөөс Эрдэнэтчүүд эрдэнэтчүүдтэй хайртай хөтөлбөрийн хүрээнд 2017, 2018 онуудад олгосон зээлийн эргэн төлөлтөөр 7,573.5 мянган төгрөгийн авлага барагдсан, ажилчидтай холбоотой он дамжсан 262.1 мянган төгрөгийг цалингаас суутган тооцсонтой холбоотой байна.



Бараа материалын дансны үлдэгдэл 23,591.3 мянган төгрөг болж 4,024.9 мянган төгрөгөөр буурсан нь ХХҮГ-ын даргын 2021 оны А/47 дугаар тушаалаар ажлын шаардлага, хэрэгцээ хангахгүй болсон шалтгаанаар 5,216.4 мянган төгрөгийн зүйлсийг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,571,354.0 мянган төгрөг болж 70,659.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны элэгдлийн зардал 101,643.8 мянган төгрөг хэдий ч үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 168,253.7 мянган төгрөгийн хөрөнгө, худалдаж авсан 4,049.9 мянган төгрөгийн /нөүтбүүк, принтер/ хөрөнгө нэмж бүртгэсэн тул үндсэн хөрөнгийн данс өссөн байна. Мөн ТӨБЗГ-ын шийдвэр зөвшөөрлөөр үлдэгдэл өртөггүй, 48,000.0 мянган төгрөгийн анхны үнэтэй Lexus 470 автомашиныг 2,500.0 мянган төгрөгөөр дуудлага худалдаанд оруулж 8,000.0 мянган төгрөгөөр худалдсан, аймгийн Засаг даргын 2021 оны А/165 тоот захирамжаар 1,959.2 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,603,978.6 мянган төгрөг болж 58,799.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 140,881.5 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар буурсан байна. Өмнөх оноос орлого буурсан нь нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 84,040.6 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 852,235.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 852,235.1 мянган төгрөгөөр тооцон баталж төсвийн хуваарь ирүүлсэн байна. /2021 оны 01 сар/.

Баталж ирүүлсэн төсвийн хуваарийг 3, 8 сард тодотгож 839,460.0 мянган төгрөгөөр, 12-р сард дахин тодотгож 58.0 төгрөгөөр нэмэгдүүлж 839,518.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71902 /Нийгмийн халамж/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 839,518.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 694,533.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 144,985.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 694,533.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 37,398.0 мянган төгрөг, нийт 731,931.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 722,342.9 мянган төгрөгийг зарцуулж 9,588.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 722,342.9 мянган төгрөг буюу 86.0 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 98,706.1 мянган төгрөгөөр, хоолны зардал 9,606.8 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 2,049.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,980.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,359.5 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.



Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж үндсэн үйл ажиллагааны орлого буюу ахмадын амралт сувиллын орлого 107,587.0 мянган төгрөгөөр тасарч /71902/ Нийгмийн халамж хөтөлбөрийн /80103/ гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ арга хэмжээний зардал гараагүйтэй /20801, 210502/ холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны 138,958.6 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна. Үүний 16,598.3 мянган төгрөг нь төвлөрүүлэх шилжүүлэг бөгөөд орон нутагт 15,794.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 149 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 2 талбарын мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, мөн тайлант онд ахмадын сангаас нийт 1,700.0 мянган төгрөгийг ахмадууддаа зориулж 2 удаа бэлэн мөнгө тарааж олгохдоо 5 хувиар



тооцож татвар суутгасан нь ХХОАТ-ын тухай хуультай, интерншип /ажлын туршлага эзэмшүүлэх/ хөтөлбөрийн хүрээнд 2 сарын турш ажлын байран дээр дадлагажиж буй залуучуудад олгосон хоол унааны зардлаас зөвхөн ХХОАТ-ын 10 хувь суутгаж олгосон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл үзүүлсэн” байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.



4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,041.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,961.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 406.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,455.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,217.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд 9,270.0 мянган төгрөгийн нэмэлт орлогын ангиллыг алдаатай илэрхийлсэн байна. Мөн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 3,691.8 мянган төгрөгийн хандивын орлогыг худалдан авсан ангиллаар толилуулсан, санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг үг үсэг, утга найруулга, мэдээллийн алдаатай бэлтгэсэн байна. Аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Тайлант онд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас нийт 4,802.6 мянган төгрөгийн шатахуун талон авч, уг шатахуун талоны урамшуулалд хүлээн авсан 144.1 мянган төгрөгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, НББ-ийн тухай хуулийн 14.4-д “...Нягтлан бодох бүртгэлд бүх орлого, бүх зардлыг заавал бүртгэнэ”, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 1-р хавсралтын 2.4-д “Үнэ төлбөргүй, хандиваар хүлээн авсан бараа бүтээгдэхүүнийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Энэ талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

2. Тус байгууллага нь бодогдсон цалин, цалингийн суутгалууд буюу цалингийн тооцооллыг алдаатай хийсэн, журналын бичилтийг цалин олгосон, ндш, ххоат болон бусад суутгал төлсөн төлбөрийн дүнгээр зардал өглөг үүсгэж хаалтын бичилт хийж гүйцэтгэсэнтэй холбоотой 262.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, хэмжилт болон үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд /11, 12-р сард/ 1,455.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны жилийн дүнгээр цалингийн зардлаас АО-с төлөх НДШ-ийн зардалд 1,688.3 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цалин, АО-с төлөх НДШ-ийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Медипас эмнэлгийн үзлэгийн төлбөрт 2021.07-р сард өмнөх оны үзлэгийн үлдэгдэл төлбөр /санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдаагүй/ 529.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-; "бүх өр төлбөр", Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж төсвийн жилд авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, санхүүгийн тайланд тусгахгүйгээр өр төлбөр үүсгэж барагдуулж буй байдлыг давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн ХХҮГ	1	262.8			1	262.8				
2	Орхон аймгийн ХХҮГ	1	144.1			1	144.1				
3	Орхон аймгийн ХХҮГ	1	1,455.0					1	1,455.0		
4	Орхон аймгийн ХХҮГ	1	1,688.3							1	1,688.3
5	Орхон аймгийн ХХҮГ	1	529.0							1	529.0
6	Орхон аймгийн ХХҮГ	1	12,961.8	1	12,961.8						
Дүн		6	17,041.0	1	12,961.8	2	406.9	1	1,455.0	2	2,217.3